

Орон бүтээлийн явдалтайн хэрэгсэлтүүн! АНХДЭГТААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 63 (2367) 1974 оны 8 дугаар сарын 23 БААСАН

МАХН-ын дайчин туслагч

МАХН-ын дайчин туслагч, бэлтгэл хүчин МХЗЭ байгуулагдснаас хойш 53 жил боллоо. МХЗЭ-ийн дайчин замнал нь эх орондоо социализм өрнүүлж байгуулж байгаа манай ард түмний тэмцэл, ялалтын түүхтэй салжгүй холбоотой юм.

МХЗЭ-ардын хувьсгалын ялалтыг бэхжүүлэхийн төлөө тулалдааны гал дунд дайчин үйл ажиллагаагаа эхэлжээ.

МАХН ардын хувьсгалыг мандуулаад хуучин төрийн аппаратыг эвдэн феодалуудын улс төр, эдийн засгийн эрх ямбыг устгах, хувьсгалт засаг төрийг бэхжүүлэн нийгмийн капиталист шатыг алгасуулан улс орноо хөгжүүлэх талаар эрэмбэ дараатай арга хэмжээнүүдийг авч явуулсан билээ.

МХЗЭ төрийн аппаратыг хувьсгалд үнэнч хүмүүсээр бэхжүүлэх, ардын дайсны хуйвалдааныг илчлэн устгах хэрэгт улс төрийн өндөр санаачлага, бадрангуу, оргилгийг оргилуулан намдаа хамгийн идэвхтэй тусалсан юм.

МХЗЭ-ийн гишүүд, залуучууд хөдөө талаар соёлын үр тарьж бичиг үсэг үл мэдэх явдлыг арилган орчин үеийн соёлшинжлэх ухаан, урлаг, утга зохиолын эх үүсвэрийг тавилцаж, улмаар ард түмний дунд түүнийг түгээн дэлгэрүүлэхэд намын өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэв.

Шинэ эдийн засгийг үүсгэн бататгах явцад буй болсон үндэсний аж үйлдвэр, тээвэр, харилцаа холбооны салбарт залуу ажилчин анги төрж ХАА-г хөгжүүлэхэд эвлэлийн гишүүд, залуучууд чухал үүрэг гүйцэтгэв.

«МХЗЭ анх үүссэн цагаас эхлэн намынхаа дайчин туслагч бэлтгэл хүчин болсоор иржээ.

Шинэ амьдрал байгуулагчдын хэдэн үе хувьсгалт залуучуудын эвлэлээр хүмүүжин улс төрийн хатуужил олсон билээ гэж МАХН, эвлэлийн үйл ажиллагааг үнэлдэг юм.

МХЗЭ байгуулагдснаасаа хойш 53 жилийн алдарт замнуулахдаа нам, засаг, ард түмэндээ өндөр үнэлгээг «Байлдааны гавьяаны одон», «Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон» болон Сүхбаатарын одонгоор 3 удаа шагнагдсан билээ.

МХЗЭ анх үүссэн цагаас эхлэн олон улсын хувьсгалт дэвшилт залуучуудын хөдөлгөөнтэй бат зузаан холбоо тогтоож тэдэнтэй хөл нийлүүлэн шинэ нийгмийг байгуулахын төлөө тэмцсэн түүхтэй.

Ялангуяа Лениний комсомолтой анхнаасаа бат журмын холбоотой явах болсон нь МХЗЭ-ийн үзэл суртал, зохион байгуулалтын өсөлт бэхжилтэд чухал ач холбогдолтой болов.

МХЗЭ—Лениний комсомол болон социалист орнуудын залуучуудын ах дүү эвлэлтэй найрамдал, хамтын ажиллагааг улам бэхжүүлэх олон улсын коммунист ардчилсан залуучуудын хөдөлгөөний эв нэгдлийг бэхжүүлэх талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

МХЗЭ—залуу үеийнхнийг Марксизм—Ленинизмын үзэл санаа, нам, ард түмэн, ахмад үеийнхний хувьсгалт дайчин хөдөлмөрч уламжлалаар хүмүүжүүлж социалист нийгмийг ухамсартайгаар гардан байгуулагчид болгон бэлтгэх үүргээ биелүүлсээр ирлээ. Эгнээндээ 120 гаруй мянган гишүүнийг нэгтгэсэн МХЗЭ энхрий хайрт намынхаа өдөр тутмын хайр халамжийг хүлээж намын удирдлага шийдвэрийг хэрэгжүүлэх үйлсэд залуучуудыг зохион байгуулан ажиллаж ирснээрээ залуучуудын улс төрийн том байгууллага боллоо өсч бэхжив. Манай өсвөрийн үеийнхээс МХЗЭ-ийн гишүүд, залуучууд эх орныхоо бүтээн байгуулалтанд хошуучилж бүх ард түмний уралдааны жил—1974 оны төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлэхийн төлөө нийт хөдөлмөрдийг хошуучилж авсан үүргээ нэр төртэй хэрэгжүүлж байна.

18300 КГ ЦАГААН АЛТ И Л У У

МАХН-ын III их хурал хуралдсаны болох БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн түүхтэй угтаж Угтаалын САА-н малчид хонин сүргийг онд тарган оруулж чадсанаар энэ жил хонь нэг бүрээс ашиглах ноосны гарцыг 480 граммаар нэмэгдүүлж 2312 грамм ноос авч сумын 1974 оны ноосны төлөвлөгөөг 18,3 тоннор, 1975 оны хөдөлшгүй төлөвлөгөөгөөр авах ноосыг 13,3 тоннор давуулж, V таван жилийн эцэст улсад тушаах ноосны төлөвлөгөөг I жилийн өмнө 18,6 хувиар давуулан тушааж өндөр амжилт гаргалаа.

Мал аж ахуйн үйлдвэрээс гаргаж байгаа бүтээгдэхүүний чанар жил дараалан нэмэгдэж, ашигт ажиллагааны түвшин байнга дээшилж байна.

Өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад нарийн ноос 2,9 дахин, нарийвтар ноос 39,9 хувиар чанарын үзүүлэлт нь дээшилж, ширүүвтэр ширүүн ноосны хувийн жин 45,7-98,7 хувиар чанарын үзүүлэлтийг сайжруулсанаас ноосноос олох ашгийг 926,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэв.

Бүх суурийн 98 хувь нь ноосны төлөвлөгөөт даалгаврыг 250—500 кг-аар давуулав.

У. ПҮРЭВЖАЛ



Залуучуудын хэвлэлийн ойн угтаж...

Залуучуудын хэвлэлийн нэгдсэн редакциас төл бэйжүүлалтын үеэр зарласан залуучуудын хэвлэлийн 50 жилийн ойн нэрэмжит уралдааны болзлыг тус аймгаас 32 залуу хангаснаас Батсүмбэрийн САА-н хоньчин Б. Түмэн-Аюуш 100 хээлтэгч бүрээс 102 төл бэйжүүлэн МХЗЭ-ийн Төв Хорооны диплом, гэрийн номын сангаар шагнагдав.

Мөн залуучуудын хэвлэлийн 50 жилийн ойн нэрэмжит АСК-ийн тэмцээнийг Зуунмод хот, Алтанбулаг, Баяндэлгэр, Лүн сумын залуучуудын дунд, нэрэмжит 7, 14 хо-

ногийн уралдааныг төл бэйжилт, техник засварын ажлаар зохион дүгнэв. Энэ уралдаанд Лүн сумын тракторч, МХЗЭ-ийн Төв Хорооны алтан медальт Нарандаш түрүүлэв.

Залуучуудын хэвлэлийн бага хурлыг аймгийн төв, хөдөөд 8000 гаруй хүнийг хамруулан хийв.

Хэвлэлийн бага хурлууд дээр залуучууд хэвлэлийн 50 жилийн ойн угтаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргахаар 650 гаруй ажилчин, малчин залуус нэмэлт үүрэг амлалт авлаа.

Д. ДЭМБЭРЭЛ

Номмунизмын оронд зочлох ажилчин



МХЗЭ-ийн Төв Хорооны тэргүүний „Ажилчин залуу“ алтан медальт үсэг өргөч Д. Лхагва „Анхдугаар таван жил“ сонин үйлдвэрийн тэргүүний сайчуудын нэг юм.

Тэрээр үйлдвэрээсээ зарласан мандатын уралдаанд 9 мандат авч жилийн төлөвлөгөөг 121,5 хувиар биелүүлэн түрүүлж ЗХУ-д үйлдвэрийн зардлаар жуулчлах эрх олж авсанд мөдхөн коммунизмын орны зүг хүлгийн жолоо залах гэж байна.

ЗУРАГ ДЭЭР:

Үсэг өргөч Д. Лхагва ажилч дээрээ.

Залуучуудын хэвлэлийн хагас зуун

ОРОН БҮХНИЙ ПРОЛЕТАРИАТ НАР
НЭГЭЭГДТҮН

Залуучуудын ҮНЭН

ЭВ ХАМТААД УРЬЖ БАЙНА

Залуурч намынхаа «Уриа» сонин дүү болж Залуучуудын эвлэлийн урагш хөтлөгч дуу болж Хувьсгалт тэмцлийн гал дунд ган шиг ширээгдсэн


Газар сайгүй шинэ соёлын үрийг тарьж Урьдын бурангуй зожиг байдлыг «цөм халаад» Ардын нэгдлийн ашид мөнхийн голомтоо тулахад ч Аж үйлдвэрийн алтан хаалгаар алхаж ороход ч Уудам монголын өсвөр үеийн багш болж Ухаант Ленин Сүхбаатарын үзлийг тэгш барьж Нам эвлэлийн мэргэн үгээр гэрэл цацраасан Насан залуусыг мэдлэг хөдөлмөрт алхаа жигдрүүлсэн Хүндэт залуусын зөвлөгч багш зөвлөх индэр Хүслэнт хэвлэлийн их ойд мэхийн ёслоёл Зээр яралзаж зэрэглээ мяралзсан говио усжуулж Зээглэн найгаж

Хуучныг халах дөл болж Зул шиг шижиртсэн Залуучуудын хэвлэлийн туулж ирсэн хагас зуун Зар баян залуу нас мэт гэрэлтэж байна! «Манай зам»-ын гэрэл туяат мөр болгон Манлай намынхаа дууг өргөн хүчин нэмж «Манай үнэн»-ийг сэрүүл тунгалаг ая дуу Мандсан орныхоо ач үрсийн замыг заалцаж Гадаад дотоодын дайны өөдөөс тулаанд орж

зэгс шиг шуугисан тариа ургуулж Одноос олон сүргийн дэргэд халаа авах Оч шиг цогтон залуу үеийнхний нөхөр байдгаар Хараа булаасан энэ хэвлэлийн хуудас бүр Хаяа захгүй тал шигээ уудам юм Хамгаалж замнасан хатан үзэл нь ариун болохоор Хан алтайн уул шигээ харахаас бахдам өндөр юм. Залуурч намын сургаалаар тархи нь мэргэн сэтгэж Залуучуудын золбоогоор зүрх нь эрүүл цохилсон Заавал ялдаг хийвэл бүтээдэг эвлэлийн хэвлэл Замбуу тивд хэл бүхэн дээр үгээ өргөн Тэргүүн дээрээ мөнх аларын одонгоо зүүгээд Тэмцэл ялалтад итгэл төгс олноо дагуулаад Тэргэл сайхан эв хамтын оргил өөд Тэнгэрлэг Монголын ач үрсийг урьж байна.

Д. ЦОДОЛ

„МАНАЙ ҮНЭН“-ИЙ ХЭВЛЭГЧ



Модон барын дурайсан том үсэгтэй монгол судар дэлгэн, үлгэр түүх уншин ярих дуртай Д. Дулам гуайтай би хэдэнтээ уулзаж танхимын сургуулийн анхны сурагч, эвлэлийн үүрийн ууган дарга нарын нэг, эвлэлийн ачаар бичиг үсэг сурснаа, оролцож явсан үйл явдлуудаа дурсан ярих дуртайгийг нь мэдэх

авч залуучуудын хэвлэлийн 50 жилийн ойн өмнөхөн дахин уулзаж ярилцав.

Д. Дулам гуай Өвөрхангай аймгийн Баян-улаан суманд 1924 онд эвлэлийн анхны үүр байгуулагдахад гишүүнээр элсэж тэндээ эвлэлийн үүрийн даргаар сонгогдон сумынхаа бүх л нутгийг морин дэл дээр туулан эвлэлийн эгнээг өргөтгөж, ардын засгийн бодлогыг олон түмэндээ

(Төгсгөл нь: III нүүрт)



Залуучуудын хэвлэлийн хагас зуун жилийн ойг тус аймгийн залуучууд ажлын өндөр амжилтаар угтав.

Лүн сумын «Энх-туул» нэгдлийн саальчин, МХЭ-ийн гишүүн Б.Цэрэнгаамаа саалийн өдөр бүрийн төлөвлөгөөг олон хувиар давуулан биелүүлж хамт олноо хошуучилж явна.

Тэрээр МАХС-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны хагас зуун жилийн ойг угтаж сүү саалийн жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлэхээр шамдан ажиллаж байна.

ЗУРАГ ДЭЭР: Б. ЦЭРЭНГААМАА.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ-ИЙН авсан гэрэл зураг

1

Ардын хувьсгалын гэрэлт сайхан наран мандаа. Тэр нарны илч гэгээ «Алтай ханганы завсар атар баялаг орон Аав ээжийн минь оршсон ашдын заяасан нутгийн» шимт хөрсөнд шинэ хөгжлийн үр үндсийг ивээн тэтгэж олон оны бөглүү харанхуйгаас ард түмэн гэгээнд гарлаа.

«Хувьсгал гэдэг үгийг сэлмээр дайсанд хэлж хурдан бууны ам улайсч байсан өдрүүдэд» тэмцлийнхээ тугийг ялалтаар мялааж эрх чөлөөг олсон туурга тусгаар улсынхаа хэтийн замыг нар болсон нам минь нийгмийн бүхэл шатыг алгасуулан хөгжил бадралын оргил коммунизм тийш заллаа. «Тэр үед үнэнийг хүнд ойгуулахад Тэрсүү дайсныг дарахаас хэцүү байсан ч үнэний гэрэл гэгээг түмэн ардад хүргэхийг хувьсгалт хөвлөдүүдэд нам даалгалаа. Тэмцлийн гал дунд хат суусан партизан дарга адил «Уриа», 1923 онд төрсөн «Манай зам» (сэтгүүл), 1924 оны 3 дугаар сарын 26-нд мөндөрсөн «Манай үнэн» (сонин) дүү нарынхаа хамт эх нутгийнхаа дөрвөн зүг, найман зовхист Алтай давж, Онон гатлан, тал туулж, говь гэтлэн хүмүүст хүрэхэд түүнээс жирийн малчин «соёлыг гайхаж» ирээдүйгээ тольдон хараад итгэл тэмүүлэл зүрхэнд нь бадрал босч байлаа.

«Манай үнэн», «Залуучуудын үнэн» бол Монголын залуу үеийг өсгөн хүмүүжүүлсэн багш, тэмцэл хөдөлмөрийнх нь баатарлаг үйлсийн толь мөн. «Манай үнэн» багшийн шавь нар «түм түмэн үрс» «Уравсан хулгай дайснуудыг Уухай хийн даралцаж» ардын засгаа хамгаалан шарын шашны бурангуй суртлыг мохоон тэмцэхдээ

«Манай залуучуудын эвлэлийг Мандах нар лугаа үлгэрлээ

2

Магадын журмыг баримталж Маш үнэнээр эвлэлдье» гэж сүрт дуугаа дуулан багшийнхаа зааснаар эвлэлийн эгнээнд нягтарч намын үйл хэрэгт дайчин туслагдах нь болж чадсан юм. «Залуучуудын үнэн» багшийн шавь нар «Залуус намын жанжин шугамаас гажигчидтай тэмцэх тэмцлийн тэргүүн эгнээнд бат чанга зогсох ёстой» гэсэн уриаг нь хэрэгжүүлэхдээ эвлэлийн үүрийн дарга Борын зоригор зүрхээ хөвчилж барууны хэлбэрэл, зүүний нугалаа, хувьсгалын эсэргүүтэй тэмцэн ялсан юм.

Монголын ард түмний тэмцэл ялалтаар

ЗАЛУУСЫН БАГШ

(НИЙТЛЭЛ)

туулсан бүхий л түүхийн замд «Залуучуудын үнэн» багштайгаа манай залуус явж нам, ард түмний даалгаврыг биелүүлж байлаа. Хөдөөгийн уул талаар соёлыг тарих их үйлсийн манлайд «Залуучуудын үнэн», «Эвлэлийн бичиг үсэг» мэдэх гишүүн бүр ядаж гэм 3 хүнийг бичиг үсэгт сургах даалгавар өгөн залуусаа илгээж байлаа.

Улсын ууган үйлдвэр болох аж үйлдвэрийн комбинатыг байгуулах ажлыг МХЭ шөфлөн авахад ажиллаж байсан залуусыг ч, шинэ залуу ажилчин ангийн эгнээнд эвлэлийн анхны илгээлт гардаж ороод бүтээх үйлсийн талбарт бүргэд зоригтоо тайхуулалсдын их хөдөлмөрийн дүнг «Залуучуудын үнэн» багш тавьж байлаа. «Тив алгасах пуужин адил Нийгэм алгасах хувьсгал хийж» бүтээн байгуулсан бүхнээ харьтнаас хамгаалахад МХЭ-ийн гал улаан бат илэрхийлэх зүрхэн

3

тус газраа нандигнасан Гонгор, Дамба, Аюуш, Олзвой, Тэгшээ, Даваадорж, дайны галын шугаман дээр гавьяагаа эх орноороо үнэлүүлсэн энэ олон баатарчууд «Залуучуудын үнэн» багшийн шавь нар байлаа. Ийнхүү баатарлаг үйлсийн халуун мөрөөр тэднийхээ уламжлалаар өсөн хүмүүжсэн дараачий нь үе «уулыг нурааж усыг эрчлүүлэх» чадлаа социалист байгуулалтын их хөдөлмөрийн фронт дээр гаргаж эгнээнийхээ тэргүүнээс БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Бямбацогт, Алтанхүү, Должинжав, Ойдовням гээд өчнөөн олон сайчуудаа төрүүлэн «Улаан туг залуучууд хоёр ихэр» явж «Уралдаан ялалт хоёрын нөхөр» байхаа үзүүлсэн, үзүүлсээр байна.

Ингэж «Залуучуудын үнэн» манай нийгмийн бүхий л хойч үеийн «ариун уураг тархинд нь ардын хувьсгалыг шингээж» намдаа шилдэг залуу коммунистуудыг бэлтгэж өгсөн гавьяат багшийн хувьд намын дэвшүүлсэн зорилтыг хөдөлмөрийн халуун цехэд зохион байгуулагчийн хувьд, залуусынхаа баатарлаг хөдөлмөр үйл явдлынх нь түүхийн тунгалаг толь мөнхийн учир ардын төрөөсөө дээдлэн авсан «Хөдөлмөрийн гавьяаны улаан туг», «Сүхбаатарын одон»-гоо тэргүүн дээрээ гялалзуулан яваа юм. Залгамж үеийн хүмүүжил чадвараас улс бүрийн хөгжлийн бялд жавхаа тодрох учраас хойч үеэ нам ард түмнийхээ хувьсгалч баатарлаг хөдөлмөрт дайчин уламжлалаар хүмүүжүүлэн «коммунизмд сургах» хариуцлага хүндтэй үүргээ биелүүлж «Залуучуудын үнэн», «Залуу үе» багш маань идэр хорин тавтын сэтгэл зүтгэлээр залуусын дунд завгүй яваа.

Ш. ЦЭРЭНДОО

ЖИЛИЙН ОЙД ХАЛУУН БАЯР ХҮРГЭЕ!

„МАНАЙ ҮНЭН“ ИЙ ХЭВЛЭГЧ

Төгсгөл. (Түрүүч нь II нүүрт)

тайлбарлан таниулж явсан хүн.

Намайг гэрт нь ороход энэ эмгэн хойморгоо үдгэрийн далай хэмээх хөдгөн судар уншиж сууснаа хойш нь тавьж надтай хуучин танилын хувиар хууч хөөрөв.

—Эвлэлд элсэхдээ би арванхоёр настай байгаа.

Суман дээрээ үүрийн гэж барьчихаад долоо хоногт 2 удаа хуралдах л даа.

Өнчин өрөөсөн хүүхдийг танхимын сургуульд суулгаж байхад миний ах Жамбаа занги гэгч хүн намайг тэнд оруулж сар гаруй ном үзүүлсэн болохоор монгол бичиг муухан гадарлах болов.

Тэгээд л үүрийн хурал дээрээ «Манай зам» сэтгүүл Ленин багшийн «Эв хамт залуучуудын зорилгоос» уншиж таниулна.

Тэгэж байтал «Манай үнэн» гэдэг нэртэйгээр залууст зориулсан сонин бичиг гарсан юм даг.

Мөн л түүний чинь уншаад л хүмүүст дуудаж өгнө...

Тэр цагийн бид чинь өдөрт хэдэн өртөө газар морины ам татахгүй давхиж ухуулга хийдэг байлаа шүү. Арван хэдтэй хүүхдийн үгийг нэгнийхээ гэрт цуглаж байгаад л сонсоно. Нам, засгийн минь бодлого ард түмэндээ тийм үнэтэй болохоор иш гэдэг байж гэж хэлээд Дулам гуай нэгийг нэхэн санаа бололтой...

—Арван долоотой Улаанбаатар хотод орж ирэв ээ. Монгол үсэг гадаргадгийнх минь ч болсон уу, эвлэлийн гишүүн, үүрийн дарга байсных ч юмуу ямарч атугай

хэвлэх үйлдвэрт 1927 онд хэвлэгчээр орсон юм.

Тэр үед манай үйлдвэр 60-аад ажилчинтай, 20-иод машинтай, би «Амерканк» гэдэг тигель машин дээр ажиллаж сураад ном сонин хэвлэж, заримдаа дэвтэрлэх тасагт ажилладаг байлаа.

Нэхэн санахад «Тоо бодлого», «Анх сурах зурхайн бичиг», зэрэг ном, «Уриа», «Манай үнэн», сонин хэвлэгддэг. Бид ч тэдгээрийг алгасалгүй уншдаг байв.

Ингэж би хөдөө уншиж танилцсан «Манай үнэн», сонингоо хэвлэлцэж явлаа.

Би хожим хөдөө гарч м а л ч и н болсон үедээ ч «Залуучуудын үнэн», сонингоо уншаар явсан. Тодорхой санахаас тэр цагт Залуучуудын сонинд бичиг үсэг мэдэх эвлэлийн гишүүн бүр ядаж 3 хүнийг бичиг үсэгт сургахыг уриалж, би ч тэр ажлыг хийхээр хичээж явсан хүний нэг гэж Дулам гуай дурсан ярьж байна.

Ийнхүү Дулам гуайтай дахин уулзаж Залуучуудын хэвлэлийн анхны уншигч, эл сонинг бүтээлцэж явсан түүхт хүн болохыг лавлаж мэдэв.

Одоо Дулам гуайн хүү Д. Балжинням ээжийнхээ залуу цагийн ажил үйлсийг нэр төртэй залгамжилж аймгийн «Анхдугаар таван жил» сонинг үйлдвэрийн тулгын чулууг туулаж эдүгээ аймгийн хэвлэлийн аварга хэвлэгч гэдэг алдрыг хүлээгээд байна.

Дулам гуай эдүгээ 60 гаруй насыг наслаж, өөрийн үр ач арав гаруй хүүхдийн хамт Зуунмод хотын I дүгээр хороонд энх тунх амьдарч байна.

Ш. ЦЭРЭНДОО

Алтанбулаг сумын «Холдмөр» нэгдлийн «Алтан оноо» бригадын хадланч Рэнцэн одор бүрийн тоололгоог 150—212 хувнаар биедүүлж хамт олбоо хошуучилж явна.

Зураг дээр: (дээд талд) морин хадуурч Рэнцэн хадлангийн талбайд, (доод талд) тус бригадын морин малчинхан

Л. ГУНГААБУУ-гийн авсан гэрэл зураг.



НЭРЭМЖИТ АЯЛАЛ

Залуучуудын хэвлэлийн 50 жилийн ой угтаж Аймгийн ХЗЭ-ийн хороо, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний зөвлөл, соёлын хэлтсээс эрхлэн аймгийн хөдөлмөр соёлын тэргүүний залуучууд, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний төлөөлөгчдийн тойрон аялалыг говийн аймгуудын чиглэлд хийлгэв.

Аялагчид эх орныхоо өмнөт нутаг Дундговь, Өмнөговь аймгууд болон өөрийн аймгийн зарим сум-нэгдлээр аялан тэндэхийн байгалийн үзэсгэлэнт байдал, түүх дурсгалт газруудаар явж говьчуудын хөдөлмөрийн гарамгай бүтээл туршлагатай танилцан өөрийн аймгийн хөдөлмөр соёлын сайчуудын баялаг туршлагаас говь нутгийн бүтээл хөдөлмөрдөд ярьж таниулав.

Тойрон аялагчид аяны

16 хоногт 2000-аад км замыг туулж БНМАУ-ын баатар, МХЗЭ-ийн үүрийн нарийн бичгийн дарга агсан эрэлхэг эмэгтэй Т.Борын төрсөн нутаг Өмнөговь аймгийн Цогтцэций, БНМАУ-ын баатар, ахмад хувьсгалч Д. Нанзадын төрсөн нутаг Манлай сумдад очиж баатруудын хөшөөний дэргэд хүндэтгэлийн цуглаан хийж хөшөөнд цэцэг өргөв.

Тойрон аялагчид аймгийнхаа дуу хуурын ая эгшгийг аялан очсон газруудынхаа хөдөлмөрдөд сонирхуулж 39 удаа концерт тоглон 8000 гаруй хүнд үзүүлсний дээр аймгийнхаа амьдралыг харуулсан «Өнөөгийн Төв аймаг» болон бусад кино 30 шахам удаа гаргаж сонирхуулжээ.

Мөн аялалын хугацаанд Баян-Өнжүүл сумын «Хайрхан» нэгдлийн хоньчин, БНМАУ-ын хөдөлмөрийн

баатар Б.Ажваа, Батсүмбэрийн САА-н саальчин БНМ АУ-ын аварга малчин Ц.Хорлоо нарын зэрэг алдар цуутнуудын туршлагыг говь нутгийн хөдөлмөрч малчдад ярьж таниулла.

Аялагчид Дон үүлдрийн ямааг буй болгосон БНМАУ-ын төрийн шагналт зоо-техникч, эрдэмтэн Т.Цэрэнсодном, Өмнөговь аймгийн Булган сумын ард, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Дамбаравжаа нарын зэрэг хөдөлмөр соёлын тэргүүний сайчууд, ахмадуудтай уулзалт 18 удаа зохиож тэдний баялаг туршлага алдар гавъяаны намтартай танилцав.

Ийнхүү энэ тойрон аялал залуучуудыг нам ард түмэн, ахмад үеийн баатарлаг уламжлал хөдөлмөрийн шилдэг үлгэр дууриаллаар хүмүүжүүлэхэд чиглэгдсэн бас нэг чухал ажил боллоо.

МАНЯЙ СУРВАЛЖЛАГЧ



Аялагчид «Залуучуудын үнэн» сонинг шинэ дугаартай танилцаж байна



■ Бүрэн сумын «Бүрэндэлгэрэх» нэгдлийн зөвлөл зун намрын отрыг зохион байгуулах тухай нэгдлийн гишүүд, хөдөлмөрчдийн хурлаар хэлэлцүүлж малдаа дээд зэргийн тарга хүч авахуулах зорилт дэвшүүлэн тавилаа.

Энэ зорилтыг биелүүлэхээр тус нэгдлийн нийт малчид Дундговь аймгийн Адаацаг, Эрдэнэдалай, өөрийн аймгийн Дэлгэрхаан сумын нутагт оторт гарлаа.

Оторт Булангаа бригадын ямаачин, сумын депутат Юндэнноров, хоньчин, сумын депутат Пагам, Хайрхан бригадын тэргүүний хоньчин Базарсад, Даваа-самбуу, Цэгмэд, Баянцогт бригадын тэр-

гүүний хоньчин Бат-очир, Шарав, Батчулуун зэрэг малчид хошуучилж явна.

Адуучин Бямбаа, Лхагважав, Дамба даржаа, Доржсүрэн, Далай нар адуугаа сувайлан Муу хөөвөр, Цагааннуур, Баянхушуу, Даац зэрэг газарт оторлон таргалуулж байна.

Ц. ДОРЖПАЛАМ

■ Заамар сумын «Заамар» нэгдлийн «Тосон» бригадын зөвлөл отор нүүдлээр алс хол яваа малчдын ар гэрийнхнийг өргөн айлсалтад буулгажээ.

Сумын УЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооноос энэ айлсалтынхны хийх ажлын төлөвлөгөөг гарган өгч соёл хүмүүжлийн ажил зохиож байна.

Саяхан сумын УЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооноос үйлчлэн сурталчлах бригад гаргаж айлсалтынханд үйлчлүүлэв.

Чөлөөлөгдсөний нь 30 жилийн ойд

СОЦИАЛИСТ РУМЫН УЛС

Наймдугаар сарын 23 бол Румыний чөлөөлөгдсөний түүхт баярын өдөр юм. Гучин жилийн тэртээ коммунист намаараа удирдуулсан Румын эх орончид Зөвлөлтийн армийн тусламжтайгаар фашистын цэргийн дарангуйлыг устгаж 1947 оны 12 дугаар сард БНУ-ыг тунхагласан юм.

БНСРУ, Европын зуун өмнөт хэсэгт оршдог бөгөөд 237,5 мянган хавтгай дөрвөлжин км дэвсгэр нутаг, 20,8 сая хүн амтай юм. БНСРУ-ын үндэсний орлого 1951—1973 онд бараг 8,3 дахин өссөний гадна улс, ардын аж ахуйд оруулсан хөрөнгө оруулалт 1973 онд урьд оныхоос 9,1 хувиар өсчээ. БНСРУ-ынаж үйлдвэрийн үйлдвэрлэл сүүлийн 23 жилд 16,3 дахин өссөний дээр 1975 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 1970 оныхоос 57,3 хувиар нэмэгдэнэ. Машины болон металл боловсруулах үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний гаргалт 1972 онд 1950 оныхоос 40 дахин өсчээ. Сүүлийн жилүүдэд нефть хийн үйлдвэрүүд түргэн хурдацтай хөгжиж 1950 онд 5 сая 47,0 мянган тонн нефть олзворлож байсан бол 1972 онд 14 сая 128 мянган тонныг олзворлон 2,8 дахин өссөн байна. ЗХУ-ын оролцоотойгоор тоноглож байгаа Борзешти хотын химийн хүчирхэг комбинат

жилд 60 мянган тонн түүхийн резин үйлдвэрлэнэ. ЗХУ-ын техник туслацаатайгаар байгуулагдсан Брашовскийн автомашины үйлдвэр нь тус орны автомашины ууган үйлдвэр юм.

Энэ үйлдвэр нь тус орны аж үйлдвэрийн объектын дотор томхон байр эзэлдэг бөгөөд «Карпачь», «Бучедж» зэрэг автомашины нь дэлхийн олон оронд гардаг.

Коксжон нүүрсний хаягдал хийгээр ажилладаг тус орны анхны ТЭЦ-ийн барилга байгууламж баригдан дуусч байна.

Шинэ таван жилд ЗХУ-ын техникийн тусламж дэмжлэгтэйгээр БНСРУ-д шинэ технологээр химийн

хэд хэдэн үйлдвэр байгуулагдаж ашиглалтад орохоос гадна металл боловсруулах металлурги, целлюлоз-цаасны аж үйлдвэрийн газрын хүч чадал нь өргөжнө.

БНСРУ-ын ХАА-н үйлдвэрлэл 1950—1973 онд 2,9 дахин өссөний гадна ХАА-н улсын үйлдвэрийн газар 200, ХАА-н хоршооллын үйлдвэрийн газрууд 4600 гаруй ажиллаж байна. ХАА-н хоршооллод үйлчилдэг техникийн станц 770 гаруй байгаагийн гадна тариалангийн талбайд 114,0 мянган трактор, 47,0 мянган комбайн ажиллаж байна. БНСРУ-д хөдөлмөрдийн аж амьдрал соёлын түвшин жил ирэх тутам сайжирч 1973 онд 146 мянган орон сууц баригдаж цалингийн доод хэмжээ

тэтгэвэр тэтгэмж дээшлэн ХАА-н хоршооллын гишүүдийн амралт сувиллын эмчилгээнд хөнгөлөлт тогтоов.

Ажилчин албан хаагчдын бодит цалин 1960—1972 онд 53 хувиар өсчээ.

Хүн амын амьдралын болон хөдөлмөрийн нөхцөл сайжирсны үрээр хүний дундаж наслалт 1932 онд 42 байсан бол одоо 70 болжээ. БНСРУ-д нийтээр арван жилийн боловсрол олгож байгаагийн дээр 1972—1973 оны хичээлийн жилд 3,2 сая хүн ерөнхий боловсролын сургуульд суралцаж байв.

ЭЗХТЗ-ийн социалист интеграцийн цогцолбор программын дагуу Социалист Румын улс нь нефть боловсруулах төхөөрөмжийн үйлдвэрийг төрөлжүүлэн хөгжүүлж байна.

Н. ХАНДСҮРЭН

МОДООР УРЛАХ ЭРДЭМ

Мужаан Хайчин гэдэг нэрийг дуулаад яагаад ч юм чихэн дээрээ хурц үзүүрт харагдаа сурмагхан тогтоож мужааны вандан дээр бөгийн суугаад харуулаа аажимхан түлхэх бүр зомгол үсчүүлэн байх өвөгжөөр нэгэн буй гэж бодож билээ.

Саяхан болтол мужаан гэвээс настайчуулын ажил мэт, мод эрхэлдэг хүн ч хуруу дарам байв.

Тэгвэл одоо дан ургамал, мод, амьтнаа эрхэлсэн аж ахуй, модон эдлэлийн бүхэл бүтэн үйлдвэр, хот хөдөөгүй байгуулагдаад нийгмийн байх нь ямар сайхан.

Тэдний нэг нь энэ буйзаа гэж аймгийн Ойн аж ахуйн харьяа төвийн модон эдлэлийн тасгаар орходоо саналаа. Мужаан

Модогдмал

ны олонхи нь залуучууд. МХЗЭ-ийн илгээлт өвөрлөн сургуулиас үйлдвэрийн цехэд очсон залуучуудын нэг нь мужаан Сүхийн Хайчин юм.

Энд тав дахь жилдээ ажиллаж буй тэр өнөөгийн ажилчин хүний юу бүтээдгийг бүтээж, эрмэлздэгийг эрмэлзэн явааг зомгол давирхай үнэртэж, их ажлын ааг амьгаалд умбасан ерөөнд нь очиж ажлаа ямар гайхамшигтай хурднаар амжуулж байхыг нь ганц удаа харахад л ойлгомжтой мэт санагдаж билээ. Мэргэжилдээ үнэнхүү дуртай, хайртай. Модоор юм хий-

хийн төлөө төрсөн юм шиг... гэж хамт олон нь магтаж байна.

Сүүлийн гурван жилийн төлөвлөгөөгөө 111—193 хувиар биелүүлсэн Хайчин энэ оныхоо ажлыг эхний хагас жилд 180 хувиар биелүүлж эдүгээ нэгэнт хоёр жилийн ажлыг хийжээ. Энэ жил 21000 төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс 50000 шахам төгрөгийн ажил хийв гэсэн энэ тоон үзүүлэлтийн цаана Хайчингийн гараар уулын эгэл мод дахин төрж танан цагаан гэрийн тооно уунаас аваад ширээ, сандал, ер хүний хэрэгтэй бүхэн болж үйлдвэрээс гарсан нь, тэр бүгдэд ур гаргаж ухаан зарж шамдсан 7 сарын нөр их хөдөлмөр нь бий. Үлдэх хугацаанд мөн нэгэн жилээс доошгүйн ажлыг хийж энэ онд ганцаараа гурван хүний ажил хийе гэсэн өндөр зорилт нь лавтайяа хэрэгжихийг үзүүлэх баримт болж харагдах бий.

Манай тасга тооныг наамлаар хийдэг байснаа заамлаар, үнийг зүсмэлээр хийхээ больж цуулбаараар хийдэг болсон.

Энэ мэтээр бүтээгдэхүүний чанарыг сайжруулахыг дор бүртээ бодож сэдэж, үүнд Хайчин гол түших хүний маань нэг болдог гэж мастер Ичинхүү өгүүлэв.

Эхний үед модны өөдөс тайрдас ёстой «гаргуундаа гарч» байлаа.

Тэгвэл одоо манайхны хийсэн жижиг ширээ сандал чинь өнөө л хаягдал маань шүү дээ.

Үүнийг санаачлагчдын нэгэн бол Хайчин гэж магтаад, хүн юу л сурна эрдэм, Хайчин бол яах аргагүй модоор юм хийх эрдэмтэй хүн гэж нэмэн өгүүлэв. Хайчин хэдий-

гээр мужааны IV зэрэгтэй, байгууллагынхаа сайчуудын нэг боловч бусдаас сурсаар өөрөө ч бусдыг сурсаар ажээ. Ахмад мужаан Мягмарсүрэн нарын олон хүнийг багшаа гэж үзэж нэгэн ёсондоо эчнээ суралцан ажилладаг гэж тэр хэлсэн. Энэ мэт сайн юм Хайчинд их гэвч, зөвхөн үүгээр түүний амжилтыг хэмжвэл өрөөсгөл дүгнэлт болох юм байна гэдгийг түүнтэй удаан ярилцсанаа дагаар мэдлээ. МХЗЭ-ийн гишүүн түүнд ХЗЭ-ийн байгууллагаас зохиох олон талт ажилд оролцох, тасгийнхаа хоёр бригадын нэгний нь ахлагч тул мужаан нарын хөдөлмөрийг зохион байгуулах түүнтэй холбогдсон тооцоо тайлан бичиг сачиуоо тайлан бичиг сачиуоо ажил, мөн хэсэг нэсгэд санаачлан СХТБ байгуулахдаа ахлагчаараа сонгосон. Ингэхлээр тун ч завгүй ажгуу. Гэвч бүтээх амжуулах сэтгэл, өндөр ухаасар нь бүхнийг хийх шавхагдашгүй хүч нь болдог байна.

Олныхоо сор болсон ийм хүнтэй уулзсан хэн боловч асууж хоргоодог ёсоор түүний ажлын аргаас сонирхоход тэрчлэлт болсон цагийг аль боло-

хоор хэмнэхийг хичээдэг.

8 цагт 1 хаалга хийхийг 4 цагт, гэрийн унь 40 цагт хийхийг 16—20 цагт гараас гаргахыг хичээж эхний үед цагтаа багтаахгүй байсан ч янз янзаар оролдож туршиж одоо өдхөн амждаг болов. Харуул хөрөө гээд багаж мохоо бол ажил мөн мохоо гэхдээ багажаа ажлын цагаар хурцлаж сууналцаг алдах бий. Хэрэглэгдэх материал урьд өдөр нь тэгэхдээ өдрийн төлөвлөгөө биелсэний дараа авч бэлтгэдэг заншилтай.

Энэ бүхнээс үзвэл Хайчин хурам бүрийг тооцож, цагийн юмыг цагт нь амжуулдаг ч барахгүй, цагийн юмыг цагаас нь өмнө гэдэг зорилгыг өмнөө дэвшүүлж, түүнээ хэрэгжүүлж чаддаг амжилтын нь нууц байна. Таван жилийн төлөвлөгөөг энэ онд биелүүлэх зорилготой ажиллаж байгаа Хайчин ингэж ажиллаад 7 дугаар сарынхаа төлөвлөгөөг 152,8 хувиар биелүүллээ.

Хөдөлмөрийн ийм сайхан дүн бол манай улсад Ойнаж ахуй байгуулагдсаны 50 жилийн ойд барьж байгаа хамгийн хүндтэй бэлэг юмаа.

Д. ЦОДОЛ

ХАЙРЦАГАН ДАРШ


Алтанбулаг сумын МЗН-ийн зөвлөлөөс эрхлэн малын тэжээлд зориулж малын төвийн айл өрхөөр модон хайрцаганд дарш хийлгэж байна. Өөсийг 1—2 см хэрчиж, цаасаар доголосон модон хайрцагт 10—15 см жигдхэн цацах журмаар 1 үе ногоо, 1 үе давс, хужир хийж сайн нягтруулахад 40 см шоо дөрвөлжин хайрцагт 1—1,5 кг давс хужир, 15 кг ногоо орж байна. Бэлчээрийн төрөл бүрийн ногоо-

гоор хийсэн сайн чанарын дарш нь 0,20 тэжээлийн нэгж гэж үзвэл 15 кг сайн чанарын дарш 3 тэжээлийн нэгж болно.

Даршныхаа чанар үр дүнг ирэх хавар шалгуулахын тулд хүлээн авахдаа хайрцаганд дээр нь жинг болон хэн хийснийг хаялаж байна. Одоогийн байдлаар 2000 гаруй кг дарш хийгээд байна. Энэ ажилд Ц. Самбуу, Цэрмаа, Цэрэнпил, Доктор нарээр бүлээрээ 150—400 кг дарш хийж ирүүлээд байна.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ



Заамар сум нэгдлийн трактор комбайнч Л. Гунцаев өвс тармах ажилд идэвх чармайлт гарган ажиллаж байна.

Л. ГУНЦАЕВУ-гийн авсан гэрэл зураг

«Анхдугаар таван жил» сонинны СХ-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.